

Төрийн бус байгууллагын татварын эрх зүйн зохицуулалт

“Ашгийн төлөө бус байгууллын эрх зүйн зохицуулалт” сургалт семинарт Татварын Ерөнхий Газрын ажилтан, Загдсүрэнгийн тавьсан илтгэл

Засгийн газар төрийн бус байгууллагыг татварын бодлогоор дэмжиж, татварын хөнгөлөлт, чөлөөлөлт эдлүүлэн, үйл ажиллагааг нь урамшуулж байгаа билээ. Аж ахуйн нэгж, байгууллагын орлогын албан татварын хуулийн 7 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 2 дахь заалтын дагуу төрийн бус байгууллагын гишүүд, дэмжигчдийн татвар, хандив, мөн хэсгийн 7 дахь заалтын дагуу нийгэмд үйлчилдэг төрийн бус байгууллагын орлогыг аж ахуйн нэгж, байгууллагын орлогын албан татвараас, Хүн амын орлогын албан татварын хуулийн 9 дүгээр бүртгэлтэй төрийн бус байгууллагад өргөсөн хандивыг хүн амын орлогын албан татвараас чөлөөлдөг. Хууль зүйн яамнаас авсан мэдээгээр 3200 орчим төрийн бус байгууллага бүртгэгдсэний 80 гаруй хувь нь “нийгэмд үйлчилдэг”, 20 орчим хувь нь “гишүүддээ үйлчилдэг” гэсэн статустайгаар бүртгэгдсэн байна.

2002 оны дүнгээр татварын албанд 1549 төрийн бус байгууллага /олон нийтийн байгууллага орсон/ бүртгэгдсэн нь дээрхи төрийн бус байгууллагын 50 орчим хувь болж байна. Эдгээр байгууллагаас жилийн эцсийн байдлаар 126 нь аж ахуйн нэгж, байгууллагын албан татварын тайлан тушааж, 11.2 сая төгрөгийн албан татвар төлсөн байна.

Дээр дурьдсан татварын албанд бүртгэлгүй аж ахуйн нэгжүүдээс цэвэр төрийн бус байгууллагаар бүртгэгдсэн нь 296 байгаа бөгөөд аж ахуйн нэгж, байгууллагын орлогын албан татварын тайланг 26 аж ахуйн нэгж тушааж, 2.4 сая төгрөгийн татвар ногдуулсан байна. Эндээс харахад төрийн бус байгууллагад маш бага татвар ногдож байгаа нь тодорхой.

Нийгэмд үйлчилдэг төрийн бус байгууллагын хувьд аж ахуйн нэгж, байгууллагын орлогын албан татварын хуулийн дагуу орлого нь албан татвараас чөлөөлөгддөг, харин гишүүддээ үйлчилдэг төрийн бус байгууллагын хувьд гишүүд, дэмжигчдийн татвар, хандивыг орлогын албан татвараас чөлөөлнө гэж заасан учир бид хууль тогтоомжид заасны дагуу холбогдох байгууллагад ашгийн бус байгууллагаар бүртгэгдсэн боловч аж ахуй, бизнесийн үйл ажиллагаа явуулж орлого, ашиг олсон байгууллага албан татвар төлөх ёстой гэсэн зарчим баримталж, энэ талаар 2002 онд Аж ахуйн нэгж, байгууллагын орлогын албан татварыг хэрэгжүүлэх аргачлалд тусгаж, хэрэгжүүлж байна. Тухайлбал: төрийн өмчийн болон хувийн их, дээд сургууль, коллеж, төлбөртэй сургалт, дамжаа хичээллүүлсэн байгууллага, төлбөртэй үйлчилгээ эрхлэгч хүн, мал эмнэлгийн байгууллага гэх мэт.